

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2021.04.30

Улаанбаатар хот

Тус компанийн Хувьцаа Эзэмшигчдийн ээлжит Хурал, хурал хийхээр товлосон зарын дагуу 2021.04.30 ны өдрийн 14 цагт Компанийн хурлын танхимд онлайнаар болов.

Хурлын дэгийн дагуу хурал эхлэхээс өмнө Тооллогын Комисс Хувьцаа Эзэмшигчдийн Хуралд ирсэн хувьцаа эзэмшигчдийн ирцийг бүртгэж, саналын эрхийн тоо, хурлын ирц, Тооллогын Комиссын 2021.04.30 ны өдрийн "Хүчин төгөлдөрт тооцох тухай" №01 тоот тогтоолыг тооллогын комиссын дарга И.Галтхүү уншиж танилцуулав. / Уг тогтоолыг хурлын материалынр хуудсанд хавсаргав./

Тооллогын Комиссын дарга И.Галтхүү : Хувьцаа Эзэмшигчдийн Ээлжит Хуралд 3.800.721 ширхэг хувьцаа эзэмшсэн 9873 хувьцаа Эзэмшигчдээс саналын эрх бүхий 2.649.178 ширхэг хувьцаа эзэмшсэн 52 хувьцаа эзэмшигч бүртгэгдсэн байна. Энэ нь нийт хувьцааны 69,7 % -ыг төлөөлж байна. Иймээс Компанийн тухай хуулийн 69-р зүйлийн 1-д заасан заалтыг үндэслэн "Хурал хүчин төгөлдөрт тооцсугай" гэв.

Үүний дараа Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга Ж.Чинзориг нээж үг хэлэв.

ТУЗ-ийн дарга Ж.Чинзориг : Дэлхий дахинд тараад буй Ковид-19 хар тахлаас үүдэн олон хүнийг нэг дор цуглуулахгүйгээр онлайнаар, халдвар хамгааллын дэглэмийг сахиж энэ удаагийн хурлыг зохион байгуулж байна. Хувьцаа эзэмшигч та бүхнийг "Махимпэкс" ХК-ийн пэйж хуудсанд хандан онлайнаар саналаа өгөхийг урьж байна гэв. Дараа нь Төлөөлөн Удирдах Зөвлөлийн тогтоолоор томилогдсон хурлын дарга Л.Янжин, Тооллогын комиссын дарга Б.Саранзаяа нар хөл хорионд орж тусгаарлагдсан учир хурлыг ТУЗ-ийн дарга Ж.Чинзориг удирдаж, Тооллогын комиссын даргаар тус компанийн нягтлан бодогч И.Галтхүү ажиллана гэж танилцуулаад хурлын нарийн бичгийн дарга, тооллогын комиссыг ажилдаа орохыг урив.

Хурал даргалагч Өнөөдрийн хурлаар:

1. Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд ТУЗ-өөс өгсөн дүгнэлтийг хэлэлцэн батлах
2. Компанийн 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах
3. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг сонгох, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2021 оны төсвийг батлах
4. Ногдол ашгийг нэгж хувьцаанд 80 төгрөгөөр хуваарилах асуудлуудыг хэлэлцэнэ гэсний дагуу хурлын дараалал ёсоор :
 1. Компанийн 2020 оны үйл ажиллагааны тайлан болон компанийн 2021 оны төлөвлөгөөг Гүйцэтгэх захирал Г.Бүдрагчаа илтгэв.
 2. Компанийн 2021 оны санхүүгийн тайлан болон Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс өгсөн дүгнэлтийг компанийн ерөнхий нягтлан бодогч Батсүх тайлагнав.
 3. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчдийн товч намтарыг танилцуулав. / "Махимпэкс" ХК-ийн дүрэмд зааснаар ТУЗ-ийн гишүүнд 9 хүн

3. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчдийн товч намтарыг танилцуулав. / "Махимпэкс" ХК-ийн дүрэмд зааснаар ТУЗ-ийн гишүүнд 9 хүн сонгогдоно. ТУЗ-ийн ердийн гишүүнээр 6 нэр дэвшигч, хараат бус гишүүнээр 3 нэр дэвшигч сонгогдоно. Энэ хуралд 13 хүн нэрээ дэвшүүлсэн гэв. /

- Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2021 оны төсвийг 12.840.000 төгрөгөөр батлуулахаар санал оруулав.

4. "Ногдол ашиг хуваарилах" тухай ТУЗ-ийн тогтоолыг танилцуулав.

Үүний дараа Хувьцаа эзэмшигчдээс ирсэн асуултыг танилцуулж холбогдох албан тушаалтан Борлуулалтын албаны дарга Болортуяа асуултанд хариулт өгөв. Асуулт : Нөөцийн махыг 2021 онд хэдэн тонн бэлтгэсэн, борлуулалт хаагуур хийгдэж байна, танай компани дээр биеэр очиж авч болох уу?

Хариулт: Манай компани 2021 онд нийт 1574 тн махыг бэлтгэсэн, нийт бэлтгэсэн махны 60% ийг хонины мах, 30% хувийг үхрийн мах, 10% хувийг эзэлж байна, Нийслэлийн засаг даргын хуваарилсан нийт 28 дэлгүүрт үүнээс Чингэлтэй Дүүрэгт 12, СХДүүрэгт 16 дэлгүүрт борлуулж байгаа, дэлгүүрээр үйлчлүүлнэ, биеэр ирж авах боломжгүй.

Асуулт :Цар тахлын үед борлуулалтын үйл ажиллагааг нэмэгдүүлэх талаар ямар ажил зохион байгуулж байна вэ?

Хариулт: Манай компани ариутгал халдваргүйтэлийн дэглэмийг сахиж 2020 оны 11-р сараас эхлэн өөрийн бүтээгдэхүүнийг гэрээсээ гаралгүйгээр гэртээ хүргүүлэх үйлчилгээг нэвтрүүлэн ажиллаж байна. Өөрийн компанийн 10 гаруй нэр төрлийн хонь, үхрийн мах болон дайвар бүтээгдэхүүнийг хүргэж өгч байна.

Асуулт: Ногдол ашгийг хэзээнээс хуваарилах вэ?

Хариулт: ТУЗ-ийн тогтоолын дагуу 2021.10.01 ний өдрөөс эхлэн хуваарилна. Дашрамд хэлэхэд 2005 оноос хойш ногдол ашгаа аваагүй хувьцаа эзэмшигчид нөхөж авч болно.

Асуулт: Цар тахлын үед зохион байгуулалтын ямар арга хэмжээ авч байна вэ?

Хариулт: Цар тахлын үед хязгаарлалтад хамрагдаагүй 15 байгууллагад багтаж байгаа, үйл ажиллагаа хэвийн явагдаж байна, халдвар хамгааллын дэглэмийг сахиж үйл ажиллагаагаа явуулж байгаагаас гадна 40 гаруй ажлын байр нэмэгдүүлж, бүх ажилчдаа вакцинд хамруулсан болно.

Хариулт: Хөдөө, орон нутагт амьдардаг хувьцаа эзэмшигчээс санал ирсэн байна. Архангай аймагт амьдардаг хувьцаа эзэмшигч байна, манай аймгаас мах бэлтгэх үү? бэлтгэвэл яаж оролцох вэ?

Хариулт: Архангай аймгаас мах бэлтгэнээ, манай мах бэлтгэлийн менежер байгаа, тэр хүнтэй уулзаарай, мал махаа өгч болно, бид нар өөрийн машиг унаагаар очиж авч болно шүү гэв.

Хурлын дарга : Өөр санал хүсэлт байхгүй тул санал хүсэлтийг үүгээр тасалъя. Та бүхний үнэтэй саналыг бид сонслоо, тэмдэглэлд тусгаж байгаа болно, хойшдын ажилдаа мөрдлөг болгоно, та бүгдэд баярлалаа. Одоо түр завсарлая, тооллогын комиссыг ажилдаа орохыг урья гэв.

Үүний дараа тооллогын комиссын дарга И.Галтхүү “ Саналын хуудсыг тоолж, дүнг танилцуулах” тухай тогтоолыг уншиж танилцуулав.

Компанийн нийт 3.800.721 ширхэг хувьцаа эзэмшиж буй 9.873 хувьцаа эзэмшигчдээс хуралд 2.646.178 ширхэг хувьцаа эзэмшсэн 52 эзэмшигч оролцов. Тооллогын комисст ирсэн саналын хуудас 52 ширхэг, үүнээс асуулга тус бүрээр хүчинтэй саналын хуудасны тоо 39, асуулга тус бүрээр хүчингүй санал хуудасны тоо 13 байна.

1. Компаний 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлахыг зөвшөөрсөн 2.157.322 ширхэг хувьцаа буюу нийт саналын 100 хувь, татгалзсан, түдгэлзсэн саналын тоо байхгүй.
2. Компанийн 2021 оны бизнесийн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлахыг зөвшөөрсөн 2.157.322 ширхэг хувьцаа буюу нийт саналын 100 хувь, татгалзсан, түдгэлзсэн саналын тоо байхгүй.
3. Компанийн ТУЗ-ийн 2021 оны зардлын төсвийг 12.840.000 төгрөгөөр батлахыг зөвшөөрсөн 2.157.322 ширхэг хувьцаа буюу нийт саналын 100 хувь, татгалзсан, түдгэлзсэн саналын тоо байхгүй.

Компанийн ТУЗ-ийн ердийн гишүүнээр:

- Ж.Чинзоригийг сонгохыг зөвшөөрсөн 2.157.270 ширхэг хувьцаа буюу нийт саналын 99,9976 хувь, татгалзсан 52 ширхэг хувьцаа буюу нийт саналын 0,0024 хувь, татгалзсан, түдгэлзсэн саналын тоо байхгүй.
- Д.Цэнддоржийг сонгохыг зөвшөөрсөн 2.157.254 ширхэг хувьцаа буюу нийт саналын 99,9968 хувь, татгалзсан 68 ширхэг хувьцаа буюу нийт саналын 0,004 хувь, түдгэлзсэн саналын тоо байхгүй.
- Ж.Баттөрийг сонгохыг 2.157.257 ширхэг хувьцаа буюу нийт саналын 99,9968 хувь, татгалзсан 68 ширхэг хувьцаа буюу нийт саналын 0,00032 хувь, түдгэлзсэн саналын тоо байхгүй.
- Л.Янжинг сонгохыг зөвшөөрсөн 2.157.257 ширхэг хувьцаа буюу нийт саналын 99,997 хувь, татгалзсан 65 ширхэг хувьцаа буюу нийт саналын 0.003 хувь, түдгэлзсэн саналын тоо байхгүй.
- Х.Цэндбаярыг сонгохыг зөвшөөрсөн 2.157.302 ширхэг хувьцаа буюу нийт саналын 99.9991 хувь, татгалзсан 20 ширхэг хувьцаа буюу нийт саналын 0.0009 хувь, түдгэлзсэн саналын тоо байхгүй.
- Д.Жанчивдоржийг сонгохыг зөвшөөрсөн 2.157.254 ширхэг хувьцаа буюу нийт саналын 99.9968 хувь, татгалзсан 68 ширхэг хувьцаа буюу саналын 0.0032 хувь, түдгэлзсэн саналын тоо байхгүй.
- Д.Даянбилгүүнийг сонгохыг зөвшөөрсөн 496 ширхэг хувьцаа буюу нийт саналын 0.023 хувь, татгалзсан 2.156.826 ширхэг хувьцаа буюу саналын 99.977 хувь, түдгэлзсэн саналын тоо байхгүй.

- Б.Лхагвадоржыг сонгохыг зөвшөөрсөн 23 ширхэг хувьцаа буюу нийт саналын 0.0011 хувь, татгалзсан 2.157.299 ширхэг хувьцаа буюу саналын 99,9989 хувь, түтгэлзсэн саналын тоо байхгүй

Компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүнээр:

- М.Баттогтохыг сонгохыг зөвшөөрсөн 2.157.254 ширхэг хувьцаа буюу нийт саналын 99.9964 хувь, татгалзсан 77 ширхэг хувьцаа буюу саналын 0.0036 хувь, түтгэлзсэн саналын тоо байхгүй.
 - Ц.Цолмонг сонгохыг зөвшөөрсөн 2.157.239 ширхэг хувьцаа буюу нийт саналын 99,9962 хувь, татгалзсан 83 ширхэг хувьцаа буюу нийт саналын 0,0038 хувь, түдгэлзсэн саналын тоо байхгүй.
 - Н.Лхачинбалыг сонгохыг зөвшөөрсөн 2.157.232 ширхэг хувьцаа буюу нийт саналын 99,9958 хувь, татгалзсан 90 ширхэг хувьцаа буюу нийт саналын 0,0042 хувь, түдгэлзсэн байхгүй
 - П.Батхишигийг сонгохыг зөвшөөрсөн 4 ширхэг хувьцаа буюу нийт саналын 0,0002 хувь, татгалзсан 2.157.318 ширхэг хувьцаа буюу нийт саналын 99,9998 хувь, түдгэлзсэн байхгүй
 - Т.Однымыг сонгохыг зөвшөөрсөн 68 ширхэг хувьцаа буюу нийт саналын 0.0032 хувь, татгалзсан 2.157.254 ширхэг хувьцаа буюу нийт саналын 99,9968 хувь, түдгэлзсэн байхгүй
4. Нэгж хувьцаанд оногдох ногдол ашгийг 80 төгрөгөөр хувиарлахыг зөвшөөрсөн 2.157.322 ширхэг хувьцаа буюу нийт саналын 100 хувь, татгалзсан, түдгэлзсэн саналын тоо байхгүй байгааг үндэслэн

ТОГТООХ НЬ: Дээрх хэлэлцсэн асуудлаар Тогтоол гаргуулахаар хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулсугай гэж танилцууллаа.

Тооллогын Комиссын дүнг үндэслэн Хувьцаа Эзэмшигчдийн Ээлжит Хурлаас №01 тоот тогтоол гаргав.

Хувьцаа Эзэмшигчдийн Хурлаас ТОГТООХ НЬ :

1. Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд ТУЗ-ийн өгсөн дүгнэлтийг зүйтэй гэж үзсүгэй
2. Компанийн 2021 оны төлөвлөгөөг баталсугай.

3. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүнээр:

- Ж.Чинзориг
- Д.Цэнддорж
- Ж.Баттөр
- Л.Янжин
- Х.Цэндбаяр
- Д.Жанчивдорж

Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүнээр:

М.Баттогтох

- Н.Лхачинбал нарыг 3 жилийн хугацаатай сонгосугай.
4. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2021 оны төсвийг 12.840.000 төгрөгөөр баталсугай.
 5. Нэгж хувьцаанд оногдох ногдол ашгийг 80 төгрөгөөр тогтоосугай гэж тогтоолыг уншиж танилцуулсанаар хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ажиллагаа өндөрлөв.

ХУРЛЫН ДАРГА

Л.ЯНЖИН

ТЭМДЭГЛЭСЭН

И.ӨЛЗИЙБАЯР

